

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР ЯВУУЛСАН БОДЛОГО /XVII- XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕ/

Л.Одзаяа

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн
ухааны сургуулийн Нийгмийн
ухааны тэнхимийн ахлах багш,
хошууч*

Товч агуулга: Манж Чин гүрэн, Хаант Орос Улс, Богд хаант Монгол Улс, Ардын эрхтэй хэмжээт цаазат Монгол улсаас дурдан буй үед хойд хилийн талаар ямар бодлого баримталж, хэрэгжүүлж байсныг өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Манж Чин гүрэн, Хаант Орос Улс, Халх, харуулын алба, 1727 оны Буурын гэрээ, 1912 оны Монгол, Оросын найрамдлын гэрээ, 1915 оны Хиагтын гурван улсын гэрээ

Үндсэн хэсэг

Манж Чин улсын төрөөс Халхын хойд зүгийн хилийн талаар баримталсан бодлого XVIII зууны эхээр монголчууд Манж Чин улсын эрхшээлд орж өөрсдийн тугаар тогтнолоо алдсан билээ.

Ингэснээр Манж Чин гүрэн Хаант Оростой газар нутгийн

хувьд шууд хязгаар залгах болж хоёр тал 1727 онд Буурын гэрээ, 1728 онд Хиагтын гэрээ байгуулсан бөгөөд эхний гэрээ нь хил хязгаар болон хилийн худалдаа хийх тухай, дараагийн гэрээ нь зөвхөн худалдааны агуулгатай байв. Ийнхүү хоёр тал гэрээ байгуулснаар Орос-Манж гүрний маргаантай олон асуудлуудыг шийдвэрлэж чадсан байна¹.

1727 оны Буурын гэрээг Манжийн талаас Түлишин, Цэрэн, Лункадо, Оросын талаас эзэн хааны туслагч Сава Владиславич нар оролцсон бөгөөд эдгээр төлөөлөгчдөөс Цэрэн нь монгол хүн байсан юм. Энэхүү гэрээ нь одоогийн Монгол Улсын хойд хилийн үндэс болсон.²

Ийнхүү Буурын гэрээг байгуулснаар³ умард хилийг сэргийлэн сахих чиг үүрэгтэй харуулын алба бий болсон. Тус алба байгуулагдсан түүхийг судлаачид өөр өөрсдийнхөөрөө дүгнэн тайлбарласан байдаг Жишээлбэл, судлаач Э.Жигмэддорж “Энэхүү алба нь биеэр болон гэр бүл, хөрөнгийн хамт тодорхой хугацаагаар томилогдон очдог байсан нь тухайн үеийн нөхцөл байдалд тохирсон зохион байгуулалт байсан⁴ гэсэн бол судлаач, Лан Мэй Хуа “Харуулын алба

¹ 1727 оны Орос-Чин улсын Буурын гэрээ. УБ.,2004. Х.4

² Б.Цэдэн-Иш. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. УБ.,2003. Х.155

³ Насанбалжир, Ц. Ар Монголоос Манжид залгуулж байсан алба. УБ.,1964. 121 дэх тал

⁴ Жигмэддорж, Э. Манжийн үеийн Ар Монгол дахь хилийн харуул. УБ.,2006. 32 дахь тал

байгуулагдсан нь хил залгаа хоёр улсын харилцааг хязгаарлан зогсоох явдал байсны зэрэгцээ харуулын албаны зардлыг монголчууд Халхын дөрвөн аймгаас төлдөг байсан¹ гэж тус тус дүгнэжээ.

Гэр харуулын талаарх тодорхойлох зураг цэсээс харвал өрх бүрд тодорхой тооны мал ногдох ба харуулын үүрэг гүйцэтгэх цэрэг бүр зэвсэг, уналгатай байсан. Улмаар 1897 оноос өртөө, харуулын албанд анх удаа үнэ хөлс тогтоосон. Тухайлбал, Харуулын өрх 980 лан, нэг бүрийн үнэ хөлс 160 лан, хөтөл 14 лан, нэг бүр 10 лан² байв. Харин Хаант оросын харуулын албанд үүрэг гүйцэтгэгчид өөрийн улсдаа татвар төлдөггүй, зөвхөн хил хязгаарыг хамгаалах үүрэгтэй байжээ.

Улмаар хязгаар нутагт харуулын алба залгуулах болсноор нутгийн иргэдтэй бэлчээрийн маргаан хийх болсон тул тэдний нутгийг зааглаж овоо босгон газрын зурагт тэмдэглэснээр Харуулын нутаг анхлан бий болжээ.

Харуулын нутгийн талаар судлаач Ц.Насанбалжир “Гэр харуулын нутагт уул дэвсгэрийн ба бусад хошуудын ардыг нутаглах явдлыг шууд хориглон цаазалж, цэс тогтоож, овоо тэмдэг

тавьж эдлүүлэн харуулын нутагт тохиолдсон хошуудын ардууд нутаг бэлчээрээр явцууран шахагдаж байсан учир, харуул ба нутгийн ардын хооронд нутаг бэлчээр булаалдах явдал олон жилийн турш үргэлжилсэн³ гэжээ. Харин судлаач Ж.Гэрэлбадрах “Хилийн харуулын нутагт аливаа хошууны иргэд болон гадаадын харьяатын орох болон нутаглахыг хязгаарлаж байсан нь хил орчмын буюу харуулын нутгийг чанд байлгах бодлого байсан⁴ гэж дүгнэсэн байдаг.

Халхууд Манж Чин улсад харуулын алба залгуулах болсноор Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийг зүүн зам, Засагт хан, Сайн ноён хоёр аймгийг баруун зам болж Улиастайн жанжны газарт захирагдаж байснаа хожим хил хязгаар, эр цэргийн асуудлыг тус тусын аймгийн чуулганы даргад захируулах болсон байна. Ингэснээр аймгийн чуулган нь хил хязгаар, харуулд сэргийлэн суулгах цэргийг боловсруулах, цэргийн зэвсгийг шалгах, цэргийн тооллого хийх, ял шүүх зэрэг явдлыг хариуцан шийдвэрлэх болсон байна.

Аймгийн чуулган нь өөр өөрсдийн аймгийн доторх өртөө харуул, албан тариалан, албан сүргийг хариулах зэрэг олон албыг хэрхэн залгуулах явдлыг

¹Лан Мэй Хуа. Монголын тусгаар тогтнолын төлөө 1911 оны хөдөлгөөн:Нэгдсэн Монгол Улс байгуулах эрмэлзэл. УБ., 2011. 82 дахь тал.

²Мөн тэнд. 73 дэх тал

³Насанбалжир, Ц. Ар Монголоос Манжид залгуулж байсан алба. УБ.,1964. Х.121

⁴Гэрэлбадрах, Ж. Монгол нутаг, дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2006.Х.142

зохицуулдаг байв. Харин зохицуулж чадахгүй зарим нэг асуудлыг Улиастайн жанжин, Хүрээний амбанд мэдэгдэж шийдвэрлүүлдэг байсан. Улмаар жил бүр Халх дөрвөн аймгийн эрх мэдэл бүхий албан тушаалтнуудыг түшмэл, бичээч, хөөгчийн хамт анги хуваан явуулж, нэгийг Хиагтын зүүн зүгийн 28 харуул, нөгөөг Хиагтын баруун зүгийн 19 харуулыг тус тус байцаан үзүүлдэг байв. Энэ зуур харуулын цэргийн зэр зэвсэг дутсан тохиолдолд тус харуулын удирдлага болон цэргүүдэд ял, торгууль ногдуулдаг байжээ.¹

Ийнхүү аймгийн чуулганыг төлөөлөгч явуулж харуулын албыг шалгахгаас гадна Улиастайн жанжин, Хүрээний сайдын газраас 10 жилд 1 удаа шалган байцаах хуультай байв.

Орос зүгийн гэр харуулын бүтэц зохион байгуулалт нь Халх дөрвөн аймаг тус бүрийн харуулыг дааж захирах засаг, товчлон захиран мэйрэн буюу залан, занги, цэргээс бүрдэж байв. Харуулыг дааж захирах засгийг Улиастайн жанжны газраас Манжийн төрд үнэнчээр зүтгэгч, итгэл хүлээсэн хүнийг томилно. Харин харуулын бусад албан тушаалтнуудыг аймгийн чуулганы газраас 3 жилийн хугацаагаар томилдог байсан.

Улмаар XX зууны эхээр манжийн гадаад, дотоодын олон асуудлын улмаас орон нутгийн болон улсын зах хязгаарын аюулгүй байдлыг хангахад анхаарах болсонтой холбоотойгоор, харуулын албыг өөрчлөх бодлого баримтлах болов. Тухайлбал, Их хүрээний цэрэг бэлтгэх газрыг байгуулж, түүнд Хиагтын зүүн, баруун зүгийн харуулыг захируулах болов.²

Харин Олноо өргөгдсөн Монгол Улс байгуулагдаж харуулын албатай холбоотой асуудлыг Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яаманд хариуцуулсан хэдий ч харуулын гүйцэтгэх үүргийг өмнөх журмаар хэвээр үлдээсэн байна.

Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын төрөөс хилийн талаар явуулсан бодлого

1912 онд Орос Монголын хооронд найрамдлын гэрээ байгуулсан бөгөөд түүний гол агуулга нь Монголын тусгаар тогтнолыг хэвээр хадгалж чадалгүй автономит эрхтэй болгон бууруулсан юм.³ Ингэхдээ тус хэлэлцээрт автономит байгууллын тухай заасан хэдий ч газар нутгийн хил хязгаарыг тодорхойлоогүй байна.⁴

Удалгүй 1913 онд Орос, Хятадын Бээжингийн

¹ Мөн тэнд. 121 дэх тал.

² Жигмэддорж, Э. Намнансүрэн, Г. Эмхэтгэл: Гэр харуулын түүхэнд холбогдох баримтууд. УБ., 2019. 123 дахь тал.

³ И. Майский. Орчин үеийн Монгол. Орч. Ц. Отхон. Х. 299

⁴ Тачибана Макото. Монголын мартагдсан түүх. УБ., 2011. Х. 90

тунхаглалаар Гадаад Монголын автономит эрхийг Хятадаар хүлээн зөвшөөрүүлсэн нэрээр Хятадын нутаг дэвсгэрийн нэг хэсэг байх болно гэж заасан бөгөөд 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Монгол Улсын нэрийг Өөртөө эзэрхсэн Гадаад Монгол хэмээн нэрлэж, түүний газар нутгийг Халхын дөрвөн аймаг, Ховдын хязгаараар тогтоохоор гурван тал ихээхэн маргалдсаны эцэст тохиролцсон явдал нь Монголчуудын өөртөө Өвөр Монгол, Баргыг нэгтгэх хэмээсэн зорилтыг тасалдуулсан явдал байв¹.

Ийнхүү дээр дурдсанчлан Хаант Оростой найрамдлын гэрээ байгуулснаар хил хамгаалалтын зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, хилийн харуулын тоог цөөтгөх бодлого явуулах болсон байна.

Тухайлбал, Халхын дөрвөн аймгаас тэгшээр гаргаж суулгасан бүгд 47 суурь харуулаас харуул тутам хоёр өрх цэргийг хэвээр үлдээж, үлдсэн 94 цэргийг уг хил, овоо, нутгийг харгалзуулахаар үлдээн тэднийг захирах түшмэдийг аймаг бүрээс сонгон томилохыг хуучин ёсоор хэвээр үлдээсэн юм².

Үүнээс гадна дээрх гэрээний дагуу Оросын харьяатуудыг харуулын нутагт түр суурьших зөвшөөрлийг Оросын хил хязгаарын асуудал эрхэлсэн

комиссар 1 жилийн хугацаатай олгох болов. Ингэснээр түр суурьших зөвшөөрөлтэй гадаадын харьяатууд харуулын нутагт өвс тэжээл бэлтгэж, малаа хариулж эхэлсэн байна.

Ийнхүү харуулын нутагт гадны харьяатууд түр суурьших болсноор харуул зангиуд хариуцсан хэсгийн газар нутгийг хамгаалахаас гадна, тэднээс бэлчээр болон байгалийн баялаг ашигласны түрээс хурааж, улсын санд нийлүүлэх нэмэлт чиг үүрэг гүйцэтгэх болов³.

Үүнээс харвал Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын үеийн хилийн харуул хамгаалалт нь хойд хөрштэй хийсэн гэрээ хэлэлцээр болон тэдний харилцаанаас хамаардаг байсан нь харагдаж байна.

Дурдан буй үед харуулд суух цэргүүдээс уг албыг орхиж нутагтаа очих тохиолдолд тэдгээр ардыг уул албанд буцааж, харуулыг орхин явагчдыг цээрлүүлж, харуулын албыг орхиогүй түшмэд, тайж нарыг сайшаан шагнасан байдаг. Мөн харуулын зарим удирдлагууд хилийн нууц арилжаа наймаа хийсний улмаас эрхээ хязгаарлуулж байсан зэрэг баримтууд архивын сан хөмрөгт хадгалагдаж байна.

*Ардын эрхтэй хэмжээт
цаазат Монгол улсын төрөөс
хилийн талаар явуулсан бодлого*

¹Монгол Улсын Гадаад хэргийн яамны Дипломат академи. Мэдээллийн дээжис. Х.13

²Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (1911-1919). УБ.,2011. 31 дэх тал

³МУУТА. А-4. Х-1. ХН-237. Нугалбар 1

Дурдан буй үед Гамингийн цэрэг монголын хойд нутгаар нэвтрэн орж хулгай дээрэм ихэссэн үе байсан тул газар орны ойр дөтийг харгалзан Хиагтын зүүн гурван харуулаас цэрэг элсүүлж, тус газар бугшиж байсан гаминг хөөн цэвэрлэх ажлыг хийх болсон байна.¹ Тухайлбал, Д.Базаржав 1921 онд 30 насандаа Хяраан харуулаас өөрийн сайн дураар ардын журамт цэрэг элсэж Хиагт болон Нийслэл хүрээг чөлөөлөх байлдаануудад оролцож явжээ.² Түүнчлэн харуул зангиуд харуулын нутгийн ойролцоох айлуудаас цэрэгт элсүүлэх ажлыг зохион байгуулах болсон байна.

Автономит болон Ардын засгийн газрын үед тус улсын харьяат болсон буриадууд болон өвөрлөгчдөд гол төлөв зах хязгаарын харуулын нутгийг шинээр олгож байсан бөгөөд “монгол хил дотор байгаа байгалийн баялаг бол монголчуудын хөрөнгө тул монгол орны газар нутгийг тус улсын харьяат болон харьяат бус хүмүүст хувьд нь эзэмшүүлж, ашиглуулахыг Ардын засгийн газраас зогсоосон байна”³. Өөрөөр хэлбэл, дурдан буй үед зарим өвөрлөгчид болон буриадуудаас харуулын нутгийг шинээр олгосон явдлыг хувьдаа өмчлөх хүсэлтүүд олонтоо гаргах

болсон бөгөөд үүнийг Засгийн газраас хүлээж авахгүй байхаар шийдвэрлэжээ.

Харин харуулын нутгийн гадаадын харьяатуудад түрээсэлж байсан явдлыг үргэлжлүүлж байв.

Мөн тус улсад газар тариаланг хөгжүүлэх явдал чухал байсан учраас Буриаддуудад тариалан эрхлэх газар олгож, боловсруулсан газраас 2 жил, атар газраас 5 жил түрээс авахгүй⁴ байхаар шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн харуулын нутагт тусгай түшмэл суулгаж, цалин хүнсийг сангаас олгуулан харьяат харуулын нутгуудыг цаггүй цагдан харгалзуулахаар⁵ тогтсон байна. Дурдсан баримтаас үзвэл харуулын нутагт түрээс хариуцсан тусгай түшмэл томилон суулгах болсон байна.

Улмаар 1923 оны 6 дугаар сарын 1-ний өдөр Харуулуудын нутгийг хошуудад буцаан олгож хариуцуулах тухай асуудлыг Засгийн газрын гишүүд хуралдаад “Хиагтын зүүн, баруун харуулуудад цагдаа цэрэг нэмж, төлөөний түшмэл томилон суулгах учрыг хэлэлцээдуул харуулуудыг татаж, тус нутгийг харьяат хошуудад олгож харгалзуулахаар тогтож, харуулын нутагт суугчдыг уугуул хошууд руу буцах эсвэл тус нутгийн харьяат хошуудад

¹ Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд. УБ.,1961. Х.42

² Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд. УБ.,1961. Х.74

³ Лувсанбалдан, Э. Монгол улсын хил хамгаалалтад холбогдох тушаал,

шийдвэр (баримтын эмхэтгэл). УБ., 1995. Х.8

⁴ Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (1911-1919). УБ.,2011. Х.12

⁵ Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (1911-1919). УБ.,2011. Х.15-16

захирагдахыг тэдний саналын дагуу шийдвэрлэхээр зохих газруудад явуулсан бөгөөд ...Дотоод явдлын яамнаас тусгай түшмэл томилон гаргаж, зах нийлэх хошуудаас түшмэлийг нэмэн авч, олон харуулуудын нутагт одуулж, өмнө ямар ямар харуулыг дагаар орсон хошуудад олгуулсан, үлдсэн нь ямар ямар хошуунд хариуцуулбал зохихыг тодорхойлуулан ирүүлэхийг Дотоод явдлын яамнаас нэн даруй эрхлэн гүйцэтгэхээр”¹ шийдвэрлэсэн байна. Үүнээс харвал Засгийн газраас харуулуудыг татан буулгахаар шийдвэрлэсэн бөгөөд харуулын нутгийг аль аль хошуунд хариуцуулахыг судлан шийдвэрлэхээр болсон байна. Харин харуулын нутагт оршин суугчдыг уугуул нутагтаа буцах эсвэл тус хошууны харьяат болохын аль нэгийг сонгох буюу тэдний хүсэлтийн дагуу шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт

Анх Манж Дайчин улсын санаачилгаар Манж Дайчин Улс Хаант Оростой хилийн хэлэлцээр (1727 онд Буурын гэрээ) хийсэн нь тус улсын умард хилийн талаар явуулах бодлогын эхлэл байв.

Автономитын үед Богд хаант Монгол Улс Хаант Оростой найрамдалт харилцаа тогтоосон тул хойд зүгийн гэр харуулын тоог цөөтгөж, харуулын нутгийг

гадаадын харьяатуудад түрээслүүлж эхэлсэн бөгөөд энэ нь Ардын засгийн үед ч хэвээр үргэлжлэв. Мөн зарим харуулын нутгийг дагаар орогсдод олгосон хэдий ч Ардын засгийн үед тус газар нутгийг хувьдаа өмчлөх явдлыг зогсоосон байна.

Ардын засгийн газраас хойд хилийн харуулуудыг татан буулгаснаар тус нутгийг язгуурын харьяат хошуудад буцааж олгохоор шийдвэрлэсэн бөгөөд түүнд оршин суугчдыг уугуул хошууд руу буцах эсвэл нутгийн харьяат хошуудад захирагдахыг тэдний саналын дагуу шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж:

1. Монгол улсын үндэсний төв архив. А-3. Х-1. ХН-845. Нугалбар 2
2. Монгол улсын үндэсний төв архив. А-4. Х-1. ХН-237. Нугалбар 1
3. Монгол улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол, шийдвэр. УБ.,1995
4. Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (Баримтын эмхэтгэл) (1911-1919). УБ.,2011
5. Эмхэтгэсэн Ж.Баттөр, Р.Мөнхтулга. Буурын гэрээ. УБ.,2004
6. Ч.Алтангэрэл нар. Монгол улсын хил хамгаалалтын түүх. УБ., 2012
7. Ж.Баттөр, Р.Мөнхтулга. Монголын дипломат бичгийн

¹ Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (1911-1919). УБ.,2011. Х.18-19

дурсгал. Боть I. (Буурын гэрээ).
Эмхэтгэл. УБ., 2004

8. Ж.Гэрэлбадрах. Монгол
нутаг дэвсгэр, хил хязгаарын
түүх. УБ., 2006

9. Э.Жигмэддорж.
Манжийн үеийн Ар Монгол дахь
хилийн харуул. УБ., 2006

10. Лан Мэй Хуа. Монголын
тусгаар тогтнолын төлөө 1911 оны
хөдөлгөөн: Нэгдсэн Монгол Улс
байгуулах эрмэлзэл. УБ., 2011

11. Ц.Насанбалжир. Ар
Монголоос Манжид залгуулж
байсан алба. УБ., 1964

12. Б.Цэдэн-Иш. Монгол
улсын хил хязгаар бүрэлдэн
тогтсон түүх. УБ., 1997